

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.12	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
	Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
	Аудитын менежер: М.Алтантуяа
	Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
	Аудитор: Г.Энхзул
Утас: 99333147 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn	
Цахим хуудас: www.audit.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.11 № 2/07
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын гарсан алдаа, зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй.

5020124

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 хөтөлбөр, 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 90 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,613,000.30	14,219,754.85
33	АВЛАГА	7,448,060.93	73,824.64
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,448,060.93	73,824.64
335	Бусад авлага	5,000,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	5,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	12,164,939.37	14,145,930.21
351	Түүхий эд материал	5,586,380.00	5,586,380.00
35110	Тусгай зориулалттай материал	5,586,380.00	5,586,380.00
354	Хангамжийн материал	6,578,559.37	8,559,550.21
35410	Бичиг хэргийн материал	298,100.00	5,285,120.00
35420	Аж ахуйн материал	3,361,700.00	3,208,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,900,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	18,759.37	66,430.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	323,057,307.14	310,783,510.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	323,057,307.14	310,783,510.67
392	Биет хөрөнгө	305,057,307.14	291,515,577.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	342,062,996.50	342,062,996.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,285,033.16)	(81,340,349.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,537,041.52	39,745,657.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,346,475.89)	(9,264,015.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,856,884.39	9,934,740.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,768,106.22)	(9,623,452.63)
393	Биет бус хөрөнгө	18,000,000.00	19,267,933.33
39301	Программ хангамж	770,000.00	1,267,933.33
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000,000.00	18,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	342,670,307.44	325,003,265.52
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	342,670,307.44	325,003,265.52
51	Засгийн газрын хувь оролцоо	342,670,307.44	325,003,265.52
512	Хуримтлагдсан үр дүн	342,670,307.44	325,003,265.52
51210	Өмнөх үеийн үр дүн	342,670,307.44	342,670,307.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	342,670,307.44	325,003,265.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	578,522,587.87	567,603,741.93

Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	269,664,587.87	17,485,754.43
120	Нийтлэг татварын бус орлого	269,664,587.87	17,485,754.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	269,647,496.50	17,055,945.33
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	17,055,945.33
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	-	429,809.10
120009	Бусад орлого	17,091.37	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,858,000.00	550,117,987.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	247,458,000.00	386,280,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	247,458,000.00	386,280,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,400,000.00	163,837,487.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	147,295,251.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,781,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,400,000.00	1,761,236.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,950,393.98	585,270,783.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,950,393.98	585,270,783.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,950,393.98	527,307,068.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,367,934.93	289,914,248.30
210101	Үндсэн цалин	126,113,289.60	178,733,286.30
210102	Нэмэгдэл	41,396,800.00	59,611,362.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,028,075.33	25,897,000.00
210104	Урамшуулал	14,829,770.00	25,672,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,942,267.05	35,219,408.48
210201	Тэтгэврийн даатгал	15,658,930.04	24,328,900.87
210202	Тэтгэмжийн даатгал	1,776,121.44	2,875,055.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,554,454.22	1,546,592.54
210204	Ажилгүйдлийн даатгал	354,016.68	1,293,771.21
210205	Эрүүл мэндийн даатгал	3,598,744.67	5,175,087.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,000,000.00	19,468,800.00
210304	Байрны түрээс	12,000,000.00	19,468,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,027,632.00	31,274,558.86
210401	Бичиг хэрэг	1,232,800.00	6,795,280.00
210402	Тээвэр, шатахуун	3,258,532.00	18,519,378.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,980,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	556,300.00	3,863,900.00
210408	Бараа материал акталсны зардал	-	116,000.00
2105	Нормативт зардал	245,600.00	1,469,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	245,600.00	1,469,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	55,000.00

Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	55,000.00
2107	Томилолт, зочны зардал	816,000.00	3,798,000.00
210702	Дотоод албан томилолт	816,000.00	3,798,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	350,960.00	107,377,710.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	106,347,614.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	122,300.00	122,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	48,900.00	94,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76,860.00	703,446.60
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	6,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	102,900.00	102,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		38,729,741.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		38,729,741.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		57,963,715.81
2132	Бусад урсгал шилжүүлэг		32,749,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	27,709,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,040,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		25,214,115.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,214,115.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(238,950,393.98)	(17,667,041.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(238,950,393.98)	(17,667,041.92)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	308,858,000.00	550,117,987.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	308,858,000.00	550,117,987.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	247,458,000.00	386,280,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	247,458,000.00	386,280,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,400,000.00	163,837,487.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	149,295,251.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,781,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,400,000.00	1,761,236.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	309,037,760.00	540,717,987.50

Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,170,782.91	482,754,271.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	197,757,905.93	286,033,631.57
210101	Үндсэн цалин	128,503,260.60	154,931,800.00
210102	Нэмэгдэл	41,396,800.00	82,869,563.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,028,075.33	22,927,218.07
210104	Урамшуулал	14,829,770.00	25,305,050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,000,356.98	34,317,129.62
210201	Тэтгэврийн даатгал	15,717,019.97	23,875,377.08
210202	Тэтгэмжийн даатгал	1,776,121.44	2,756,733.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,554,454.22	1,469,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	354,016.68	1,251,940.29
210205	Эрүүл мэндийн даатгал	3,598,744.67	4,963,878.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,000,000.00	19,468,800.00
210304	Байрны түрээс	12,000,000.00	19,468,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,540,200.00	7,679,800.00
210401	Бичиг хэрэг	700,000.00	1,839,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,260,200.00	3,260,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,980,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00
2105	Нормативт зардал	245,600.00	2,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	245,600.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	153,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	153,200.00
2107	Томилолт, зочны зардал	496,000.00	3,798,000.00
210702	Дотоод албан томилолт	496,000.00	3,798,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,930,720.00	129,303,710.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,400,000.00	128,273,613.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	122,300.00	122,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	48,900.00	94,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	153,720.00	703,446.60
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	6,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	205,800.00	102,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,866,977.09	57,963,715.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	32,749,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	27,709,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,040,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,866,977.09	25,214,115.81

Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,866,977.09	25,214,115.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(179,760.00)	9,400,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	9,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	9,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	9,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	9,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(9,400,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(179,760.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	342,670,307.44	-	342,670,307.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	73,823.00	-	73,823.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	342,744,130.44	-	342,744,130.44
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,667,041.92)	-	(17,667,041.92)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	325,077,088.52	-	325,077,088.52
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	325,077,088.52	-	325,077,088.52
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	325,077,088.52	-	325,077,088.52
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,667,041.92)	-	(17,667,041.92)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	307,410,046.60	-	307,410,046.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,342,900.00	362,834,620.29	23,508,279.71	93.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,342,900.00	362,834,620.29	23,508,279.71	93.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	358,633,300.00	335,125,020.29	23,508,279.71	93.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,843,800.00	273,299,169.07	20,544,630.93	93.01
210101	Үндсэн цалин	154,931,800.00	154,931,800.00	-	100.00
210102	Нэмэгдэл	73,112,200.00	70,135,101.00	2,977,099.00	95.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,744,700.00	22,927,218.07	13,817,481.93	62.40
210104	Урамшуулал	29,055,100.00	25,305,050.00	3,750,050.00	87.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,730,400.00	33,819,954.62	2,910,445.38	92.08
210201	Тэтгэврийн даатгал	24,976,700.00	23,378,202.08	1,598,497.92	93.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,938,400.00	2,756,733.97	181,666.03	93.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,469,200.00	1,469,200.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,469,200.00	1,251,940.29	217,259.71	85.21
210205	Эрүүл мэндийн даатгал	5,876,900.00	4,963,878.28	913,021.72	84.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,468,800.00	19,468,800.00	-	100.00
210304	Байрны түрээс	19,468,800.00	19,468,800.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,829,800.00	6,829,800.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	989,600.00	989,600.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	3,260,200.00	3,260,200.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,980,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	153,200.00	153,200.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	153,200.00	153,200.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	538,700.00	524,000.00	14,700.00	97.27
210702	Дотоод албан томилолт	538,700.00	524,000.00	14,700.00	97.27

Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,068,600.00	1,030,096.60	38,503.40	96.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	122,300.00	122,300.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	129,400.00	94,950.00	34,450.00	73.38
210804	Тээврийн хэрэгслийн татвар	707,500.00	703,446.60	4,053.40	99.43
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	6,500.00	6,500.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	102,900.00	102,900.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,709,600.00	27,709,600.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,709,600.00	27,709,600.00	-	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,709,600.00	27,709,600.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	358,599,900.00	386,280,500.00	(27,680,600.00)	107.72
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	386,280,500.00	(386,280,500.00)	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	386,280,500.00	(386,280,500.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	11.00	11.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,400,000.00	163,837,487.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,400,000.00	163,837,487.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,400,000.00	157,029,251.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	12,734,462.50

210102	Нэмэгдэл	-	12,734,462.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	497,175.00
210201	Тэтгэврийн даатгал	-	497,175.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	850,000.00
210401	Бичиг хэрэг	-	850,000.00
2105	Нормативт зардал	-	2,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,274,000.00
210702	Дотоод албан томилолт	-	3,274,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,400,000.00	137,673,613.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,400,000.00	137,673,613.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,040,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,040,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,040,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	162,076,251.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	162,076,251.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	149,295,251.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,781,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргаа нь эрхэм зорилгоо “Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, орон нутгийн салбар дундын зохицуулалтыг хангах Усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх юм.” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/641 дугаар тушаалаар баталсан " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,740.9 мянган төгрөг буюу 5.18 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ	ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ	ДҮН	ЭЗЛЭХ ХУВЬ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,613.00	5.72	14,145.93	4.35	(5,467.07)	(27.87)
АВЛАГА	7,448.06	2.17	1.64	0.00	(7,448.06)	(100.00)
БАРАА МАТЕРИАЛ	12,164.94	3.55	14,145.93	4.35	1,980.99	16.28
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	323,057.31	94.28	310,783.51	95.65	(12,273.79)	69.18
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	323,057.31	94.28	310,783.51	95.65	(12,273.79)	(3.80)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	342,670.31	100.00	324,929.44	100.00	(17,740.86)	(5.18)

ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	342,670.31	100.00	324,929.44	100.00	(17,740.86)	(5.18)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	342,670.31	100.00	324,929.44	100.00	(17,740.86)	(5.18)

Авлагын данс эхний үлдэгдэл 7,448.1 мянган төгрөгийн ажиллагсадтай холбогдсон авлага, байгууллагаас авах авлагатай байсныг барагдуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 310,783.51 мянган төгрөг болж өмнөх оноос 12,273.79 мянган төгрөгөөр буурсан байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 818 тогтоолыг үндэслэн 47,671.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн байна. Мөн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн 370 дугаар захирамжаар Хиймэл нуур ХХК-аас 9,400.0 мянган төгрөгийн цахилгаан соронзон усны урсгалын хурд хэмжигч худалдаж авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14,145.9 мянган төгрөг болж өмнөх оноос 1,980.9 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 429.8 мянган төгрөгийн бараа материал үнэгүй авсан ба бичиг хэргийн материал мөн өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 273,126.2 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 113,216.7 мянган төгрөгөөр илүү, 386,342.9 мянган төгрөг болгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 386,342.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 362,834.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	358,633.3	335,125.0	23,508.3	93.5
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	27,709.6	27,709.6	-	100
Нийт дүн		386,342.9	362,834.6	23,508.3	193.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 163,837.5 мянган төгрөг орсныг зориулалтын дагуу зарцуулж, 1,761.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн Байгаль орчин аялал жуулчлалын газрын санхүүжилтээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, сургалт зэрэг Монгол улсын засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 2 дугаар тогтоолын хүрээнд зарцуулсан байна.

Хүснэгт 2. Нэмэлт санхүүжилтийн орлого

Огноо	Байгууллагын нэр	Орлого
2024-02-19	Баянхонгор аймгийн Засаг дарга	15,231.6
2024-03-12	БОАЖГазар	134,063.6
2024-04-04	Усны газар	7,741.0
2024-04-23	Шаргалжуут рашаан сувилал	1,761.2
2024-12-24	БОАЖЯам	5,040.0
Нийт дүн		163,837.5

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргаа нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 199 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардал 583,320.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,833.2 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 3,791.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 510,496.7 мянган төгрөгийн санхүүжилт 128,800.8 мянган төгрөгийн зарлагын мэдээллийг хуулийн дагуу бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитаар 99,709.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 85 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	5,000.00	1	5,000.00	100%
	1	94,708.90	1	94,708.90	100%
Нийт дүн	2	99,708.90	2	99,708.90	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/889 дугаар тушаал “Урамшуулал олгох тухай”-д Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон харьяа байгууллагын дарга нарын 2024 оны сүүлийн хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг 85-100 оноо буюу “Маш сайн” үнэлэгдсэн албан хаагчдад үндсэн цалингийн 100%-ийн урамшуулал олгохыг байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсний дагуу тухайн байгууллагын дарга Б.Ням-Очир-т олгосон байна. Энэ нь Монгол улсын газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний 5 дугаар тогтоол 2 дугаар зүйл “Төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр тооцон олгох нийтлэг мөнгөн урамшуулал” 2.2 Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд дараагийн аудитаар уг асуудлыг анхаарч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,097.6 мянган төгрөгийн 2 алдаа¹, 1 зөрчил илрэв. Үүнд:

1. Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,950.0 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснийг үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

2. Санхүүгийн байдлын тайланд ХХОАТ-ын 73.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй өмнөх үеийн үр дүн рүү бичилт хийж хаасан байна.

Дээрх 2 алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3. Ажилчидтай холбоотой 73.8 мянган төгрөгийн байгууллагаас төлөх ХХОАТ-ын авлагыг барагдуулаагүй байна.

Аудитаар илрүүлсэн нийт 2,097.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 3,791.6 мянган төгрөгөөс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Ажилчидтай холбоотой 73.8 мянган төгрөгийн байгууллагаас төлөх ХХОАТ-ын авлагыг барагдуулаагүй өмнөх үеийн үр дүнгийн данс руу хаасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 үнэн зөв байх, 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар 73.8 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,950.0 мянган төгрөгийн санхүүжилт орж ирснийг үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байна.	1	1,950.0	1	1,950.0			1	1,950.0		
Санхүүгийн байдлын тайланд өмнөх үеийн үр дүн рүү 73.8 мянган төгрөгөөр бичилт хийж хаасан байна.	1	73.8			1	73.8	1	73.8		
Дүн	2	2,023.8			1	73.8	2	2,023.8		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилчидтай холбоотой 73.8 мянган төгрөгийн байгууллагаас төлөх ХХОАТ-ын авлагыг барагдуулаагүй байна.	1	73.8	1	73.8				
Дүн	1	73.8	1	73.8				

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 02/571284/БНА-2025/117/
НА - СТА - ТШЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилчидтай холбоотой 73,800 (Далан гурван мянга найман зуун) төгрөгийн авлагыг барагдуулаагүй өмнөх үеийн үр дүнгийн данс руу хаасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 бүх өр төлбөр, 5 дугаар зүйлийн 5.1.4 үнэн зөв байх, 20 дугаар зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны буруутай албан тушаалтнаар 73,800 (Далан гурван мянга найман зуун) төгрөгийг нөхөн

5050004

төлүүлж Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог нуурын сав газрын захиргааны дарга Б.Ням-Очир, нягтлан бодогч А.Одгэрэл нарт даалгав^{2,3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

АУДИТОР

Г.ЭНХЗУЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно